



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 26 өдөр

Дугаар

19/19

Номгон

**Аймгийн 2020 онд худалдах
үл хөдлөх хөрөнгийн жагсаалт батлах,
хөрөнгө актлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 367 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус XIX хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчид бүртгэлтэй 2020 онд худалдах хөрөнгийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, актлах хөрөнгийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдах үл хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар тогтоолгож, дуудлагын худалдаа зохион байгуулах газар, хугацаа, орлого төвлөрүүлэх дансны мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Төсөвт байгууллагуудын үл хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны орлогоос үнэлгээ хийлгэсэн ажлын хөлс, бусад холбогдох зардлыг хассан дүнгээр орон нутгийн төсөвт төвлөрүүлсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190055

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны
12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус XIX хуралдааны
19/19 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭЛТЭЙ 2020 ОНД ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглагдаж орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Газрын хэмжээ	Тайлбар
1	Жинст сум	ЗДТГ	Орон сууц	88.01.02	1	13693716,7	13 693 716,70	11880288,32	1 813 428,38	70м2	Шугаман цутгамал суурьтай, 60мм блок ханатай, модон хучилттай, шувуу нуруутай, 70м2 талбай бүхий газартай. Үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоох
2	Жинст сум	Соёлын төв	Клубийн барилга	97.01.01	1	27582309,4	27 582 309,40	23541472,88	4 040 836,52	312м2	Шугаман цутгамал суурьтай, даацын тоосго, блок дүүргэгчтэй, шувуу нуруутай, модон дээвэртэй 312м2 талбай бүхий газартай. Үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоох
ДҮН									5854264,90		

ооо

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны
12 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит бус XIX хуралдааны
19/19 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭЛТЭЙ 2020 ОНД АКТЛАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгуу- лагын нэр	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нэг бүр- ийн үнэ	Бүгд үнэ	Элэгдэл	Үлдэх өртөг	Газрын хэмжээ	Тайлбар
1	Гурван- булаг сум	ЗДТГ	Хуучин конторын барилга	74.08.25	1	188951000,00	188951000,00	188951000,00	0,00	1700м2	Конторын барилга нь 1974 онд сургуулийн зориулалттай баригдаж 1976 онд суулт өгсөний улмаас зарим хэсгийг нурааж байсан. Модон хана, модон хучилттай 1080 м2 талбайтай, 1995-2016 он хүртэл ЗДТГ-ын Конторын барилгаар ашиглагдаж байсан. 2007 онд Хаалга, цонх, гадна дотор хананд их засварын ажлыг 10 сая төгрөгөөр Жам ХХК гүйцэтгэсэн. 2009 онд Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ашиглах боломжгүй тухай дүгнэлт гарч байсан. Хөрөнгө дахин үнэлгээнд ороогүй. 2018 оны үнэлгээгээр 1700 м2 газрыг 3,4 сая төгрөгөөр үнэлж бүртгэсэн. Барилгыг акалж газрыг чөлөөлж газар эзэмших эрхийг эзэмшигч байгууллагад хэвээр үлдээх
2	Гурван- булаг сум	ЗДТГ	Худгын байшин	98.01.01	1	1013000,00	1013000,00	448057,00	564943,00		Голын хажууд байдаг худгийн байшин. Хуучин цаг уурын харуулын байраар зундаа ашиглаж байсан. Одоо ашиглалтгүй сургаан байшин дотор гадна дулаалгагүй. Газрын гэрчилгээ аваагүй зөвхөн модыг нь үнэлж худалдах

3	Гурванбула г сум	ЭМТ	Эмнэлгийн хуучин барилга	98.01.01	1	88348400,00	88348400,00	65495287,25	22853112,75	2170м2	Одоо бүх цонх хагархай, барилгын суурт суулт өгсөн, дэвээр хэсгээр дусаал дусдаг цаашид ашиглагдах боломжгүй.эмнэлгийн барилга. нь 1998 онд эмнэлгийн зориулалттай баригдсан. Модон хана, модон хучилттай 283,5 м2 талбатай. 2000-2010 он хүртэл ЭМТ-ийн барилгаар ашиглагдаж байгаад 2010 оноос хойш ашиглагдаагүй. Одоо бүх цонх хагархай, барилгын суурт суулт өгсөн, дэвээр хэсгээр дусаал дусдаг цаашид ашиглагдах боломжгүй. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас ашиглах боломжгүй тухай дүгнэлт гарсан. 2018 онд 2170м2 талбай бүхий газрыг 4340,0 мянган төгрөгөөр дахин үнэлж бүртгэсэн.Барилгыг акталж газрыг чөлөөлж газар эзэмших эрхийг эзэмшигч байгууллагад хэвээр үлдээх	
4	Баянговь сум	ЗДТГ	4-р багийн хуучин барилга	85.01.01	1	5168119,42	5 168 119,42	430676,64	4 737 442,78	1000м2	Уг барилгыг 1985 онд Ленинч нэгдлийн гишүүд аж ахуйн аргаар барисан.Модон барилга одоогоор ашиглалт байхгүй багийн шинэ барилгатай болсон.Үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоож худалдах.2018 онд дахин үнэлгээ хийсэн. Мөн 1000м2 талбай бүхий газрыг дахин үнэлж 2,0 сая төгрөгөөр бүртгэсэн. Барилгыг акталж газрыг чөлөөлж газар эзэмших эрхийг эзэмшигч байгууллагад хэвээр үлдээх	
					4,00	283480519,42	283480519,42	255325020,89	28155498,53			
					ДҮН							